



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/305

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд Хэрлэн суманд хэрэгжих Хүндэтгэлийн хаалга орчим мод тарих газрын хашааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга: Ц.Дэмбэрэлсайхан -Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн
дарга: И.Баасанжав -Орон нутгийн өмчийн газрын
худалдан авах ажиллагааны
мэргэжилтэн

Гишүүд: Ц.Бат-Эрдэнэ -Хөрөнгө оруулалт, хөгжлийн
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
хөрөнгө оруулалт өмчийн бодлого
хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

